

## МАН-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Х.БУЛГАНТУЯАГИЙН ХЭЛСЭН ҮГ

*Эрхэмсэг хатагтай, ноёд оо!*

1949 оны 10 сарын 16-нд, Монгол Хятад хоёр улс дипломат харилцаа тогтоож, БНХАУ-ын Ерөнхий сайд Жөү Энъ Лай, БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбал нарын харилцан айлчлалаар өнөөгийн олон талт хамтын ажиллагааны эхлэл тавигдсан билээ. Энэхүү 64 жилийн хугацаанд манай хоёр орны хамтын ажиллагаанд багагүй саад бэрхшээл тулгарсан ч бид найрсаг хөршийн харилцааг хадгалж, улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал хийгээд, ард түмний өөрсдийнх нь сонгосон хөгжлийн замыг харилцан хүндэтгэсээр ирсэн билээ.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газрын харилцаа сүүлийн жилүүдэд хурдацтай хөгжиж, өндөр дээд хэмжээний уулзалт тогтворжиж, улс төрийн харилцан итгэлцэл гүнзгийрч, хүмүүнлэг, соёл, боловсрол, худалдаа, эдийн засаг, батлан хамгаалах зэрэг салбарын хамтын ажиллагаа өргөжин олон улсын болон бүс нутгийн үйл хэрэгт нягт уялдаатай хамтран ажиллаж байгаа нь сайшаалтай. Энэхүү найрсаг харилцаа, хамтын ажиллагааны нэгээхэн хэсэг болж миний бие Хятад улсад бакалаврын зэрэг хамгаалах алтан боломж олдсонд олзуурхаж явдгаа энд хэлмээр байна.

2011 онд хоёр улс стратегийн түншлэлийн харилцааг тогтоосон нь түүхэн онцгой үйл явдал болсон. Улмаар, 2013 онд энэхүү харилцааг хөгжүүлэх дунд, урт хугацааны хөтөлбөрт талууд гарын үсэг зурсанаар хоёр улсын стратегийн түншлэлийг тасралтгүй бэхжүүлэн гүнзгийрүүлэх, бүх салбарын хамтын ажиллагааг төлөвлөгөөтэй, үе шаттайгаар урагшлуулан хөгжүүлэх, бүс нутаг улмаар дэлхий дахины энх тайвныг сахин хамгаалах, тогтвортой байдал, хөгжлийг урагшлуулах боломжийг бий болгосон юм.

Хятад улс нь манай гадаад худалдааны хамгийн том түнш юм. 1990 онд хоёр талын хооронд хийгдсэн худалдааны хэмжээ дөнгөж 33,6 сая ам доллар байсан бол 2008 оны үзүүлэлтээр 2,8 тэрбум ам.доллар болж 18 жилийн хугацаанд 83 дахин, 2013 оны 2 дугаар улирлын байдлаар Монгол улсын нийт экспортын 87.9 хувийг, нийт импортын 25,1 хувийг, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 10 хувийг тус тус Хятад улс дангаараа эзэлж байгаа нь Хятад улс манай улсын эдийн засаг, худалдааны салбарын голлох түнш орон гэдгийг харуулж байна.

Хоёр орны ард түмний найрсаг харилцаа, хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлэхэд манай хоёр улс төрийн намууд тэргүүлэх үүрэг гүйцэтгэсээр ирсэн болохыг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

90 жилийн түүхтэй Хятадын Коммунист нам, Монгол Ардын нам хоорондын харилцаа, хамтын ажиллагаа жилээс жилд улам бүр өргөжин тэлж байгаад сэтгэл хангалуун байдаг. ХКН-ын 18 дугаар Их хурлын Гуравдугаар бага хурлаас гарсан *"Шинэчлэл өөрчлөлтийг бүх талаар гүнзгийрүүлэх нэн чухал асуудлуудын тухай"* 16 бүлэг 60 зүйл бүхий Төв Хорооны шийдвэр нь цаг үеэ олсон, оновчтой болсон. Энэхүү шийдвэр нь амжилттай хэрэгжиж Хятадын ард түмэнд үр өгөөжөө өгнө гэдэгт итгэлтэй байна.

Хятадын онцлогтой социализмын механизмыг сайжруулан хөгжүүлж, Хятад үндэстний агуу их сэргэн мандалтын *"Хятад мөрөөдөл"*-ийг биелүүлэхийн төлөөх үйлсэд шинэчлэл өөрчлөлтийг бүх талаар гүнзгийрүүлэх тэр дундаа төрийн өмч зонхилсон олон төрлийн өмчит аж ахуйг хамтад нь хөгжүүлэх, шинжлэх ухаанд тулгуурласан санхүүгийн татварын системийг хөгжүүлэх, хот хөдөөгийн хоёрдмол хөгжлийн бүтцийг боловсронгуй болгох, нээлттэй эдийн засгийн шинэ механизм болон чөлөөт худалдааны бүсийг хурдацтай байгуулах зэрэг нь нэн чухал ач холбогдолтой юм.

Энэхүү шийдвэрүүд нь Хятад улс дэлхий дахинд нээлттэй бодлогоо улам бүр гүнзгийрүүлж байгаагийн тод илрэл юм. Цаашид Хятад улс хөрш зэргэлдээ улс орнуудтайгаа харилцах бодлогодоо харилцан ашигтай, хамтдаа хожих нээлттэй

стратегийг тууштай баримтлан гадаадад нээлттэй байдлаа улам гүнзгийрүүлж байгаа нь мөнхийн хөрш Монгол улсын хувьд хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг улам бүр өргөжүүлэн хөгжүүлэх боломж гэж итгэж байна.

Өнөөдрийн зохион байгуулагдаж буй "БНХАУ дахь шинэтгэл, нээлттэй бодлогын гүнзгийрэлт-Монгол Хятадын харилцааг хөгжүүлэх шинэ боломж" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал" манай хоёр улсын стратегийн түншлэлийг өргөжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт би эргэлзэхгүй байна. Энэхүү хурлыг зохион байгуулж буй БНХАУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын яам, ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнд талархал илэрхийлье.

Эрдэм шинжилгээний хуралд оролцож буй төлөөлөгчдөд амжилт хүсч, мөнхийн хөрш манай хоёр орны найрсаг, харилцан бие биенээ хүндэтгэсэн олон талт харилцаа, хамтын ажиллагаа улам гүнзгийрэн хөгжиж, хамтдаа хөгжин дэвшихийн ерөөлийг дэвшүүлье.

*Анхаарал тавьсанд баярлалаа.*